

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН
ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН**

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Горчинсүрэн Нэр: Адъяа Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.4 дэх хэсэгт Улсын Их Хурал энэ хуулийн 35.3-т заасан нэр дэвшигчийн сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-131 дүгээр зүйлийг баримтлан дараах ажиллагааг явууллаа. 1/Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дэргэдэх Хөдөлмөр Нийгмийн Харилцааны дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш Горчинсүрэнгийн Адъяаг нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно. 2/2025.06.18-ны өдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолыг баталж, 2025.07.01-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарыг томилсон. 3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд: -Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан -Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, dobu.mn, medee.mn, ergelt.mn, dnn.mn сайтад 30 хоногийн хугацаанд давтамжтай байршуулж мөн “Өдрийн сонин”-д зар тавьсан.	

-Сонсголд асуулт асууж, үг хэлэхээр Б.Гүнжилмаа, Ч. Бат-Эрдэнэ нар сонсголд оролцлоо.

-2025.06.26-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Д.Далхжав** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2025.06.27-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

4/2025.07.01-ний өдрийн 09:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн **С.Зулпхар** даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Баясгалан, Б.Бейсен, Х.Болормаа, Х.Булгантуяа, М.Ганхүлэг, Д.Ганмаа, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа, О.Саранчулуун, М.Сарнай, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат нарын гишүүд оролцсон.

5/Нэр дэвшигч **Г.Адъяа** нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч **Д.Далхжав** дүгнэлтээ танилцуулсан.

6/Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Б.Бейсен нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин: Нийгмийн даатгалын сангийн оролцогчдыг хэрхэн тодорхойлох, аль оролцогчид ашиг, алдагдлыг хүлээх талаар, Нийгмийн даатгалын сангийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен: Тэтгэврийн насанд хүрсэн хүнийг Үндэсний зөвлөлд дэвшүүлж байгаа нь хэр оновчтой талаар, олон жил ажилласан даатгуулагч тэтгэврийн доод хэмжээг авч байгаа нь шударга эсэх, хэрхэн тэтгэврийн хэмжээг шударгаар нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй иргэд эрүүл мэндийн үйлчилгээг авч чадахгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар асуулт асуулаа.

7/Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан бүртгүүлсэн оролцогчид асуулт асууж, хариулт авсан.

Оролцогч Б.Гүнжилмаа: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү шилжих боломжийг хаасан, энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн үр шимээ хүртэх боломжийг олгох чиглэлд ямар ажил

хийх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ямар бодлого баримтлах талаар, даатгуулагч хөгжлийн бэрхшээлтэй болохоос өмнө төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг хэрхэн зохицуулах талаар;

Оролцогч Ч.Бат-Эрдэнэ: Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг хэрхэн оновчтой болгох талаар, Монгол улсад авч хэрэгжүүлэх боломжтой бусад улсын сайн туршлагын талаар, нэр дэвшигч улс төрийн намын гишүүн эсэх, улс төрийн намаас ангид ажиллаж чадах эсэх талаар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүд нь бүгд тэтгэврийн насны хүмүүс байгаа нь оновчтой эсэх, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг Улсын Их Хуралд санал болгохдоо Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо хэрхэн сонгон шалгаруулсан талаар асуулт асуулаа.

8/Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хараат бус, мэргэжлийн хүрээнд нийгмийн даатгалын бодлогыг хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн **Ж.Баясгалан** хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн нэг төлөөлөл тул цаашид эдгээр иргэдийн эрхийг хангах чиглэлд анхааран ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн **О.Саранчулуун** үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагчийг нөхөн сэргээх, хөдөлмөр эрхлэхэд чиглүүлэх талаар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн **Д.Үүрийнтуяа** Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт, шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн хүний хувьд саналаа оруулан ажиллах, аливаа улс орон, салбарын бодлогод ахмад настай, туршлагатай хүний оролцоо чухал талаар, **С.Эрдэнэбат** Үндэсний зөвлөлийн хурлыг иргэд олон нийтэд нээлттэй хийх, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн даатгалыг үр ашигтай, даатгуулагчид ээлтэй зарцуулахад анхаарах талаар, урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч **Ч.Бат-Эрдэнэ** Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашигтай, оновчтой зарцуулах, даатгуулагчийн эрх ашгийг хангах чиглэлд анхааран ажиллах талаар тус тус үг хэллээ.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч С.Зулпхар хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч С.Зулпхар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчийн нээлттэй сонсголыг зохион байгууллаа. Сонсголыг нэгтгэн дүгнэвэл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, даатгуулагч, олон нийтийг бодит судалгаанд суурилсан мэдээллээр хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах, тэтгэврийн хуримтлалын санг баялгийн сантай уялдуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах зэрэг чиглэлд анхаарч ажиллах нь зүйтэй байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133.1-д заасны дагуу сонсголд оролцсон гишүүд сонсгол явуулснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргаж ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Парламентын цахим хуудаст байршуулах талаар оролцогчдод мэдээлэл өгсөн болно.

3	Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд
----------	--

	<p>оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.4 дэх хэсэгт Улсын Их Хурал энэ хуулийн 35.3-т заасан нэр дэвшигчийн сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025.07.01-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны Үндсэн хууль танхимд зохион байгууллаа.</p> <p>Сонсголд Нийгмийн бодлогын байнгын хорооны 15 гишүүн, нэр дэвшигч Г.Адъяа, Хараат бус шинжээч Д.Далхжав, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Отгонтунгалаг, Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга М.Нямдаваа, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны тэтгэмжийн даатгалын сан хариуцсан аудитор шинжээч Л.Ган-Өлзий, иргэдийн төлөөллөөс Б.Гүнжилмаа, Ч.Бат-Эрдэнэ нар оролцлоо.</p> <p>Сонсголд оролцсон Улсын Их Хурлын 2 гишүүн, урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн 2 иргэн нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан болно.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.1 дэх хэсэгт заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2025.07.01-ний өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа.</p>
4	<p>Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Хөдөлмөр Нийгмийн Харилцааны дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш Горчинсүрэнгийн Адъяаг нэр дэвшүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдвол:</p> <p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчдын төлөөлсөн гишүүнээр сонгогдсон нөхцөлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд олгосон чиг үүргийг хэрэгжүүлж даатгуулагчдын эрх ашгийг төлөөлөн нийгмийн түншлэгч талуудтай ажил хэрэгчээр хамтран ажиллах болно. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүний хувьд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, даатгуулагч төвтэй нийгмийн даатгалын үйлчилгээг үндэсний хэмжээнд хөгжүүлэх, төлөвшүүлэхэд өөрийн мэдлэг, туршлагаа зориулах болно. Төрөөс Нийгмийн даатгалын тогтолцоог даатгуулагчид ээлтэй болгох чиглэлээр хийхийг зорьж буй шинэчлэлийг дэмжиж холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчдын хүсэл, сонирхолд нийцсэн байдлаар хөгжүүлэх,</p>

даатгалын сангуудаас шимтгэл төлөгч-даатгуулагчдад үзүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний хүрээг хөгжингүй орнуудын жишгээр нэмэгдүүлэхэд онцгой анхаарах болно. Тухайлбал Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн удирдлага зохион байгуулалтыг Германы туршлагаар өөрчлөн осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, даатгуулагч осол, өвчлөлд өртсөн тохиолдолд нөхөн сэргээх даатгалын байгууллагын үндсэн үйлчилгээг хөгжүүлэх, шимтгэл төлөгч-ажил олгогчдод даатгалын сангаас үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгохыг зорьж байна.

Цаашид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж нь даатгуулагчийн зөвхөн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн шинэчлэлийг шуурхай хийхэд анхаарна. Тэтгэврийн гурван давхаргат тогтолцоог дэмжиж тэтгэвэр авагч амьжиргаагаа хангахуйц тэтгэвэртэй байх нөхцөлийг шуурхай бүрдүүлэхийн төлөө ажиллана.

Мөн тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих бодлогын хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх, бэлтгэл хангах, үндэсний хөтөлбөр боловсруулах асуудал санаачилна.

Нийгмийн даатгалын тогтолцооны бие даасан, хараат бус байдлыг хангаж өөрийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарах, Нийгмийн даатгалын тогтолцоог улс төрийн нөлөөлөл, сонгуулийн амлалтуудаас ангид байлгах чиглэлээр ажиллах, Нийгмийн даатгалын тогтолцооны орц ба гарц буюу шимтгэл төлөгчид, тэтгэвэр, тэтгэмж олголтод шударга ёсны зарчмыг баримтлах, Олон улсад хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн орнуудад тулгамдаж буй бэрхшээлийг судлан үзэх, орлогыг нэмэгдүүлэхийн тулд баялгийн сантай холбох тохиолдолд тодорхой хязгаарлалт тавьж тогтвортой байдлыг хангахад онцгойлон анхаарах, өндөр насны тэтгэвэр авагсдын тэтгэврийг улс орны эдийн засгийн хөгжилтэй уялдуулан нэмэгдүүлэх аргачлал боловсруулж өндөр настнуудад эх орны хөгжлийн үр шимийг тэгш хүртээх зорилго тавьж ажиллана.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах (Цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан осол, гамшиг олширч буйг харгалзан), даатгуулагч төвтэй Нийгмийн даатгалын үндэсний тогтолцоог төлөвшүүлэхэд даатгуулагчид, шимтгэл төлөгчдийн оролцоо, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлэх, бүх шатны Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг ил тод байдлыг дээшлүүлж тэдний даатгуулагчидтай ажиллах, зөвлөн туслах ажлын арга барилыг эрс шинэчлэхэд Нийгмийн даатгалын даатгуулагчдыг төлөөлсөн гишүүд онцгой анхаарна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийг сайжруулахын тулд иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг өргөжүүлэх, үүнд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. Ялангуяа хувийн хэвшлийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд, албан бус салбарт ажиллагсдад онцгой анхаарал хандуулахаа илэрхийлсэн.

2/Хараат бус шинжээч Д.Далхжав:

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 06 сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийг мэдлэг, мэргэшил, үр чадвар,

ёс зүй, туршлагын талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр миний бие томилогдсоны дагуу нэр дэвшигч Горчинсүрэн овогтой Адъяагийн бүрдүүлсэн материал болон ярилцлагын үеэр асуусан асуултад хариулсан байдалд үндэслэн шинжээчийн дүгнэлтийг гаргалаа.

Мэдлэгийн талаар: Хүн сургалтаар мэдлэгийг олж авдаг. Г.Адъяагийн тухайд 1963-1971 онд Сүхбаатар аймгийн Онгон сумын ерөнхий боловсролын сургуульд 1-8 дугаар анги дүүргэж бүрэн бус дунд боловсролтой болсон. 1971-1974 онд Дархан хотод /хуучин нэршлээр/ "Политехникум /хуучин нэрээр/ төгсөж "Механик" мэргэжлийн тусгай дунд боловсрол эзэмшсэн бол 1982-1987 онд ОХУ-ын Москва хотын Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний дээд сургуульд суралцаж "Хөдөлмөрийн эдийн засагч" мэргэжлээр бакалавр зэрэгтэй болсон. 2002-2004 онд мөн сургуулийнхаа докторын хөтөлбөрт элсэн суралцаж "Эдийн засгийн ухааны доктор"-ын зэрэг хамгаалсан байна.

Г.Адъяагийн суралцсан байдлаас үзвэл өөрийгөө тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн шат шатны сургалтуудад хамрагдаж хөдөлмөрийн болон эдийн засагийн чиглэлээр тодорхой мэдлэг олж авсан болох нь сургалтын байгууллагуудаас олгосон дипломуудаар нотлогдож байна. Нийгмийн даатгалын үйл ажиллагаа нь хөдөлмөрийн болон санхүүгийн харилцааны хүрээнд зохицуулагдаж байдаг тул мэдлэг талаасаа энэ албан тушаалд нэр дэвшүүлсэн нь зөрчилдөх зүйлгүй гэж үзэв.

Мэргэшлийн талаар: Ажил үүрэг гүйцэтгэхэд мэдлэгээс гадна мэргэшил, ур чадвар заавал шаардагдана. Хүн ажил үүрэг гүйцэтгэх явцдаа мэргэшил, ур чадварыг эзэмшдэг. Мэдлэгтэй, мэргэшсэн хүнд тухайн ажил үүргийг гүйцэтгэх хандлага төлөвшдөг. Нэр дэвшигч Г.Адъяагийн ирүүлсэн төрийн албан хаагчийн анкет, баримт бичгүүдтэй танилцахад 1979 оноос өнөөг хүртэл хөдөлмөр нийгмийн хамгааллын чиглэлээр тасралтгүй ажиллаж ирсэн нь салбарын хувьд туршлагажсан гэж үзэх үндэслэл байна. Нэр дэвшигчийн мэдээлэл нэр дэвших болсон үндэслэлтэй танилцахад Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчин, даатгуулагчдын хамрагдалт, шимтгэл төлөлт, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх боломж, сангийн хөрөнгийн зохистой ашиглалт, өр төлбөр тооцооллын талаар дэвшүүлсэн санаанууд нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалан ажиллах мэргэшил, дадлага туршлагатай болохыг илтгэж байна.

Ур чадварын талаар: Манай улсад 1990 оноос өмнө өнөөгийн хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын гүйцэтгэж буй үүргүүдийн тодорхой хэсгийг Монголын үйлдвэрчний эвлэлийн байгууллага хариуцан ажилладаг байсан. Тухайн үеэс эхлэн нэр дэвшигчийн гүйцэтгэж ирсэн ажил албан тушаал, бичиж туурвисан бүтээлүүдтэй түүхчилсэн байдлаар танилцан судалж үзэхэд хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашиг, нийгмийн хамгаалал, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын талаар тодорхой ажил албан тушаалуудыг дамжин үүрэг гүйцэтгэж ирсэн болох нь ажиглагдлаа. Нэр дэвшигчийн ажил үүрэг гүйцэтгэх ур чадварыг илүү тодруулах зорилгоор мэргэжлийн түвшинд цөөн тооны асуултыг тавихад онол арга зүйн түвшинд оновчтой хариултыг өгч байсан болно. Мөн түүнчлэн УИХ-ын гишүүн, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын орон тооны зөвлөх зэрэг төр, олон нийтийн төлөөллийн байгууллагуудад өндөр ажил албан тушаалуудыг гүйцэтгэж ирснээс үзвэл хамт олны төлөөлөл болон ажиллах ур чадвар эзэмшсэн гэж үзэх үндэслэлтэй.

Ёс зүйн талаар: Г.Адъяа нь дээд боловсролын байгууллагад багш, судлаач сурган хүмүүжүүлэгчээр тодорхой хугацаанд ажиллаж ирсэн болох нь баримт бичгийн хүрээнд нотлогдож байгаа тул нийгмийн харилцааны ёс зүйн хэм хэмжээг сахиж, бусдад эерэг талаараа үлгэрлэл болж ирсэн байх магадлалтай. Мөн түүнчлэн төр олон нийтийн байгууллагын сонгуульт албанд удаа дараа сонгогдон тушаал дэвшин ажиллаж ирснээс үзвэл өөрт ногдуулсан үүрэг хариуцлагыг ухамсарлан ойлгох ёс зүйтэй хамт олон болон системийн байгууллагадаа хүлээн зөвшөөрөгдсөн, сонгогч олон түмний итгэлийг даах ёс зүй төлөвшсөн хүн гэж дүгнэв.

Туршлагын талаар Нэр дэвшигчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл ажлын дадлага туршлагын талаар ирүүлсэн баримт бичигт судалгаа хийж үзвэл 1979 оноос өнөөг хүртэл 45 жил хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой нэг салбарт ажиллажээ. Монголын үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь 1990 оноос өмнө ч одоо ч ажлын чиг үүргийн хувьд хөдөлмөр эрхлэгчид, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалж ажилладаг тул Г.Адъяа нь нийгмийн даатгалын хууль, эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг туршлагатай болсон гэж үзэх үндэслэл байна. Шинжээчийн тухайд дүгнэлтийн үнэний магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор түүнтэй нийгмийн даатгалын хууль эрх зүй болон сангийн удирдлагын талаар асуулт тавьж хариултыг авсан болно. Нотлох баримт, асуултад хариулсан байдалд үндэслэн Г.Адъяа нь туршлагын хувьд нэр дэвшсэн албан тушаалд нийцнэ хэмээн дүгнэв.

Дүгнэлт: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигч Г.Адъяа нь мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын хувьд тавигдах шалгуурыг бүрэн хангасан гэж дүгнэв.

Дүгнэлтийг хүснэгтлэн харуулбал:

Мэдлэг	Мэргэшил	Ур чадвар	Ёс зүй	Туршлага
+	+	+	+	+

Тэмдэглээний тайлал: Шаардлага хангасан /+/ Шаардлага хангаагүй /-/

3/Хаалттай хурлын тайлан

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч **Г.Адъяаг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд **олонх буюу 84 хувийн саналаар дэмжлээ.**

Сонсгол даргалагч:

С.ЗУЛПХАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

